

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
Г.ГЭРЭЛТУЯАГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ,
ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)**

Байгууллагын нэр: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар

Нэгжийн нэр: Газар зохион байгуулалтын хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1.1. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах					
1.	Арга хэмжээ 1.1.1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх болон тодотгон боловсруулах ажлын даалгаврыг батлуулж, явцын хяналт хийх	60	10	70	
2.	Арга хэмжээ 1.1.2. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчилж байгаа болон тодотгол хийж байгаа аймгуудын төлөвлөгөөний арга хэмжээг "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем"-д оруулах ажлыг зохион байгуулах	60	10	70	
Зорилт 1.2. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд хяналт тавих.					
3.	Арга хэмжээ 1.2.1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргах, үнэлэх	60	10	70	
Зорилт 1.3. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах					
4.	Арга хэмжээ 1.3.1. Шинээр боловсруулагдаж байгаа сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын явцад хяналт хийж, дүгнэлт гаргах..	60	10	70	
Зорилт 1.4. Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох					
5.	Арга хэмжээ 1.4.1.				

	“Газар зохион байгуулалт хийх журам”-ын төслийг боловсруулах	60	10	70	
6.	Арга хэмжээ 1.4.2. “Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар”-ын төслийг боловсруулах, батлуулах	60	10	70	
7.	Арга хэмжээ 1.4.2. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэглээ, ач холбогдлын талаар видео танилцуулга бэлтгэж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилах	49	0	49	
Зорилт 1.5.Тусгай зөвшөөрөл болон мэргэжлийн байгууллагын эрх олгох, сунгах, хүчингүй болгох, хяналт тавих ажлыг зохион байгуулах					
8.	Арга хэмжээ 1.5.1. Салбарын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, тайланг хүлээн авч хянан гэрээг дүгнэж, акт үйлдэх	60	10	70	
Зорилт 1.6. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх					
9.	Арга хэмжээ 1.6.1. 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтын төслийг боловсруулах ажлыг зохион байгуулж, батлуулах	60	10	70	
10.	Арга хэмжээ 1.6.2. 2025 оны сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах	60	10	70	
Зорилт 1.7.Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж					
11.	Арга хэмжээ 1.7.1. Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах	60	10	70	
12.	Арга хэмжээ 1.7.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх	60	10	70	
13.	Арга хэмжээ 1.7.3. Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах	60	10	70	
14.	Арга хэмжээ 1.7.4. Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах	60	10	70	

15.	Арга хэмжээ 1.7.5. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх	60	10	70	
Нэмэлт үүрэг даалгаварын биелэлт					
16.	Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дүгнэлт гаргах	60	10	70	
Дундаж оноо:				68,7	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 18-ны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эх хэл, бичиг үсэг, түүх, соёлын дурсгалаа судалж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.	100	15	
2.	Газар зохион байгуулалтын мэргэшсэн инженерийн сургалтад хамрагдсан байна.	—	—	
Дундаж оноо			15	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	7	
3.	Асуудал шийдвэрлэх	7	
4.	Хариуцлагатай байдал	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
8.	Мэргэжлийн ур чадвар 3.		
Дундаж оноо		7	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		8


5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	(70 хүртэлх оноо) 68,7
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	(15 хүртэлх оноо) 15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	(7 хүртэлх оноо) 7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	(8 хүртэлх оноо) 8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо)
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		98,7

Үнэлгээ өгсөн:

ГЗБ-ын хэлтсийн дарга
(албан тушаал)

Нэгжийн дарга


(гарын үсэг)

/Ц.Ихбаяр/
(албан хаагчийн нэр)
2024.12.04
(огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Газар зохион байгуулалтын
төлөвлөлт хариуцсан ахлах
мэргэжилтэн
(албан тушаал)

Төрийн жинхэнэ албан хаагч:


(гарын үсэг)

/Г.Гэрэлтуяа/
(албан хаагчийн нэр)
2024.12.04
(огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:


Төрийн захиргаа, удирдлагын
газрын даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч
(албан тушаал)


(гарын үсэг)

/Б.Энхболд/
(албан хаагчийн нэр)
2024.12.19
(огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн асуудал
хариуцсан ахлах мэргэжилтэн
(албан тушаал)


(гарын үсэг)

/С.Ганцэцэг/
(албан хаагчийн нэр)
2024.12.19
(огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Ерөнхий газрын дарга
(албан тушаал)

Төсвийн шууд захирагч


(гарын үсэг)

/А.ЭНХМАНЛАЙ/
(албан хаагчийн нэр)
2024.12.19
(огноо)



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.ГЭРЭЛТУЯАГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	4	5			
1		2	3				6	7	
Зорилт 1.1. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах									
1.	Арга хэмжээ 1.1.1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх болон тодотгон боловсруулах ажлын даалгаврыг батлуулж, явцын хяналт хийх	Говь-Алтай, Өвөрхангай, Ховд, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Хөвсгөл, Өмнөговь	17 аймгийн ГЗБЕТ /Увс, Завхан, Хөвсгөл, Өмнөговь, Дундговь, Төв, Дархан-Уул, Дорноговь, Өлгий, Булган, Баянхонгор, Орхон, Архангай, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Сэлэнгэ/ боловсруулсан.	1-р сард: Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө шинэчлэх болон тодотгох аймгуудад ажлын даалгавар боловсруулах чиглэлийг хүргүүлсэн байна. 2-р сард: Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврыг хянаж, аймгийн ГХБХБГ-т хүргүүлсэн байна. 3-6-р сард: Өвөрхангай, Хөвсгөл аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврыг хянаж, аймгийн ГХБХБГ-т хүргүүлсэн байна. 7-12-р сард: Говь-Алтай, Өвөрхангай, Ховд, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Хөвсгөл, Өмнөговь, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврыг хянаж, аймгийн ГХБХБГ-т хүргүүлсэн байна.	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах жишиг ажлын даалгаврын төслийг боловсруулан 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Дархан-Уул, Ховд, Өвөрхангай, Дорноговь, Өмнөговь, Хөвсгөл, Говьсүмбэр аймгийн ГХБХБГ-т 2024 оны 01 дүгээр сарын 03-ны 1/11 дүгээр албан бичгээр чиглэл, жишиг ажлын даалгаврын загварыг хүргүүлсэн.	01-12	100		

					зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 14-ний 2-р хурлаар Говь-Алтай аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөл, 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 3-р хурлаар Өмнөговь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төслийг тус тус хэлэлцүүлж, захиалагчийн хяналтыг хийж дүгнэлт гарган Говь-Алтай аймагт 2024 оны 07 дугаар сарын 04-ний 1/1705, Өмнөговь аймагт 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 1/2408 дугаар албан бичгээр хүргүүлж ажилласан.		
2.	Арга хэмжээ 1.1.2. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө шинэчилж байгаа болон тодотгол хийж байгаа аймгуудын төлөвлөгөөний арга хэмжээг "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем"-д оруулах ажлыг зохион байгуулах	Говь-Алтай Өвөрхангай, Ховд, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Хөвсгөл, Өмнөговь	17 аймгийн ГЗБЕТ Увс, Завхан, Хөвсгөл, Өмнөговь, Дундговь, Төв, Дархан-Уул, Дорноговь, Баян-Өлгий, Булган, Баянхонгор, Орхон, Архангай, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Сэлэнгэ/ боловсруулсан.	Эхний хагас жилд: Говь-Алтай аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний зураг, тайланг "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем"-д оруулж мэдээллийн сан үүсгэх ажлыг зохион байгуулсан байна. Жилийн эцэст: Өвөрхангай, Ховд, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Хөвсгөл, Өмнөговь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний зураг, тайланг "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем"-д оруулж мэдээллийн сан үүсгэх ажлыг зохион байгуулсан байна.	Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд Говь-Алтай аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2024-02-082-6568 дугаартай төсөл үүсгэн төлөвлөсөн 10572, Өмнөговь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2023-02-046-8035 дугаартай төсөлд 14304, Дархан-Уул аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 2024-02-045-8728 дугаартай төсөлд 4465 арга хэмжээг тус тус мэдээллийн санд бүртгэсэн. Мөн аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж байгаа Ховд аймгийн төлөвлөгөөнд 2024-02-084-9121, Говьсүмбэр аймгийн төлөвлөгөөнд 2024-02-042-8366, Дорноговь аймгийн төлөвлөгөөнд 2024-02-044-8935 дугаартай төслүүдийг цахим системд үүсгэсэн...	01-12	100
Зорилт 1.2. Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд хяналт тавих.							
3	Арга хэмжээ 1.2.1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргах, үнэлэх	8 Төлөвлөгөөний хэрэгжилт	17 аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө (Увс, Завхан, Хөвсгөл, Өмнөговь,	1,2-р сард: 8 аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэж гаргаж ГНС-ын тайланд	2024 оны газрын нэгдмэл сангийн тайланд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний биелэлтийг гарган мэдээллийг тусгуулан, ДДЗХ-аар 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр танилцуулж, Газрын нэгдмэл	01-06	100

		Дундговь, Төв, Дархан-Уул, Баян-Дорноговь, Өлгий, Булган, Баянхонгор, Орхон)-г боловсруулсан.	холбогдох мэдээллийг оруулсан байна. 3-6-р сард: Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хянаж, холбогдох дүгнэлт, зөвлөмжийг аймгийн ГХБХБГ-т хүргүүлсэн байна.	сангийн тайланг Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Хэрэгжилтийг тайлагнах, хянах асуудлыг Газар зохион байгуулалт хийх журамд тусган Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолоор батлуулсан. 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан 21 аймгийн ГХБХБГ-ын Газар зохион байгуулалтын төлөвлөлт хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтаар аймгуудын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг танилцуулж, цаашид авах арга хэмжээний талаар чиглэл өгч ажилласан. Мөн 17 аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хянаж, аймгуудын ГХБХБГ-т 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 502 дугаар албан бичгээр зөвлөмж чиглэлийг хүргүүлсэн.			
Зорилт 1.3. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах							
4	Арга хэмжээ 1.3.1. Шинээр боловсруулагдаж байгаа сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын явцад хяналт хийж, дүгнэлт гаргах.	Увс, Дархан-Уул аймгийн 15 сум	175 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулсан.	Эхний хагас жилд: Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний явцын тайлан ирүүлсэн тухай бүр ойн сан бүхий газрын газар зохион байгуулалтын төлөвлөлтөд хяналт хийсэн байна. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө ирүүлсэн 5 сумын төлөвлөгөөг нэгтгэн, дүгнэлтийг гаргаж, аймгийн ГХБХБГ болон гүйцэтгэгчид хүргүүлсэн байна. Жилийн эцэст: Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний явцын тайлан ирүүлсэн тухай бүр ойн сан бүхий газрын газар зохион	Завхан аймгийн Шилүүстэй, Цэцэн-Уул, Тэлмэн, Асгат, Түдэвтэй, Сонгино, Баянхонгор аймгийн Баян-Овоо, Бөмбөгөр, Орхон аймгийн Жаргалант, Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумдын нийт 4 аймгийн 10 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хөдөө аж ахуйн газрын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, зам шугам, сүлжээний газрын төлөвлөлтөд хяналт хийж, дүгнэлт гаргасан. Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний төсөлд дүгнэлт гаргаж аймгийн ГХБХБГ-т 2024 оны 09 дүгээр сарын 06-ны 1/2353, гүйцэтгэгчид 1/2352 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	01-12	100

				байгуулалтын төлөвлөлтөд хяналт хийсэн байна. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө ирүүлсэн 10 сумын төлөвлөгөөг нэгтгэн, дүгнэлтийг гаргаж, аймгийн ГХБХБГ болон гүйцэтгэгчид хүргүүлсэн байна.			
Зорилт 1.4. Захирагааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох							
5	Арга хэмжээ 1.4.1. "Газар зохион байгуулалт хийх журам"-ын төслийг боловсруулах	Журмын төсөл, Засгийн газрын тогтоолын төсөл	Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан.	Эхний хагас жилд: Газар зохион байгуулалт хийх журмын төсөлд шаардлагатай мэдээлэл, холбогдох материалаар ЗГХЭГ-г хангасан байна. "Газар зохион байгуулалт хийх журам"-ын төслийг батлуулах ажлыг зохион байгуулсан байна. Жилийн эцэст: "Газар зохион байгуулалт хийх журам"-ыг холбогдох байгууллагууд, олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулсан байна.	Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 92 дугаар тогтоолоор "Газар зохион байгуулалт хийх журам"-ыг шинэчлэн батлуулсан. Батлагдсан газар зохион байгуулалт хийх журмыг сурталчлах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. - Дорноговь аймагт 2024 оны 04 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд зохион байгуулагдсан бүсчилсэн сургалтад Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудал, Газар зохион байгуулалт хийх шинэчилсэн журмын чиглэлээр чадавхжуулах сургалтыг хийсэн. - Газар зохион байгуулалт болон хот төлөвлөлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагыг чадавхжуулах сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан. - 21 аймгийн ГХБХБГ-ын Газар зохион байгуулалтын төлөвлөлт хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 06-нд зохион байгуулсан. - 21 аймгийн ГХБХБГ, нийслэлийн ГЗБА-нд Газрын тухай хуульд орсон өөрчлөлт, шинэчлэн батлагдсан Газар зохион байгуулалт хийх журмыг сурталчлах ажлыг зохион	01-12	100

					байгуулах чиглэлийг 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 1/1708 дугаар албан бичгээр хүргүүлсэн. - Нийслэлийн ГЗБА-ны мэдээллийн цагаар танилцуулах шинэчлэн батлагдсан журам, тухайн жилийн төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудал сэдвээр танилцуулгыг бэлтгэсэн.			
6	Арга хэмжээ 1.4.2. “Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар”-ын төслийг боловсруулах, батлуулах	1 заавар	Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан.	3,4-р сард: “Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар”-ыг боловсруулж, холбогдох байгууллагуудаас саналыг авч, нэгтгэсэн байна. 5,6-р сард: Аргачилсан зааварт саналуудыг тусган шинэчлэн боловсруулж, ГЗБ-ын орон тооны бус мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн байна. Жилийн эцэст: “Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар”-ыг ДДЗХ-аар хэлэлцүүлж, батлуулсан байна.	“Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар”-ын төслийг боловсруулж 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил, орон зайн төлөвлөлтийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, тулгамдаж буй асуудлууд сэдэвт салбар дундын хурал”, 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан газар зохион байгуулалт болон хот байгуулалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн байгууллагуудын сургалт, 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан 21 аймгийн ГХБХБГ-ын Газар зохион байгуулалтын төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт, 2024 оны 6 дугаар сарын 14-ны өдөр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурал, 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр биологичдыг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулж санал авсан. Мөн 21 аймгийн ГХБХБГ, нийслэлийн ГЗБА-нд 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/1523, холбогдох яамд, их дээд сургуулиуд, холбоодод 2024	03-12	100	

					оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 2087, 2088, 2089, 2090, 2091, 2092, 2093, 2094, 2095, 2096 дугаар албан бичгүүдийг хүргүүлж, мөн тус газрын газар, хэлтсүүдээс саналыг тус тус авч тусган Газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/305 дугаар тушаалаар аргачлалыг батлуулсан.		
7	Арга хэмжээ 1.4.2. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэглээ, ач холбогдлын талаар видео танилцуулга бэлтгэж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах	1 танилцуулга	1-3-р сард: Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэглээ, ач холбогдлын талаар танилцуулгын мэдээллийг бэлтгэсэн байна. 4-6-р сард: Танилцуулгыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулсан байна.		Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэглээ, ач холбогдлын талаарх судалгаа, мэдээллийг бэлтгэсэн. Видео танилцуулгыг санхүүжүүлэх төсөл тус газартай байгуулах гэрээ хийгдээгүй байгаа тул хүлээгдэж байна.	01-06	100
Зорилт 1.5. Тусгай зөвшөөрөл болон мэргэжлийн байгууллагын эрх олгох, сунгах, хүчингүй болгох, хяналт тавих ажлыг зохион байгуулах							
8	Арга хэмжээ 1.5.1. Салбарын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, тайланг хүлээн авч хянан гэрээг дүгнэж, акт үйлдэх	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн тоо	2023 онд хүсэлт ирүүлсэн 48 аж ахуйн нэгжийн хяналт хийж, дүгнэлтээр АМХ-т хүлээлгэн өгсөн. 2023 оны 451 тайланг хуулийн этгээдүүдээс цахим системээр хүлээн авсан.	Эхний хагас жилд: Газар зохион байгуулалтын чиглэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн 2023 оны үйл ажиллагаа эрхэлсэн дэлгэрэнгүй тайланг хянаж, мэдээллийн санд тэмдэглэл хөтөлнө.	"Лалпанд эко" ХХК-аас ирүүлсэн газар зохион байгуулалтын чиглэлээр гүйцэтгэсэн тайланг хүлээн авч дүгнэн, актыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүлээлгэн өгч мэдээллийн сангаар тайлан илгээх талаар зөвлөмж өгсөн. Мөн Газар зохион байгуулалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн байгууллагуудын 2024 оны тайлан хүлээн авч хянахаар 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр зарлалыг тус газрын цахим хаягт байршуулсан.	03-12	100
Зорилт 1.6. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх							
9	Арга хэмжээ 1.6.1. 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтын төслийг боловсруулах ажлыг	21 аймаг, нийслэл, 9 дүүрэг	2023 онд Газрын хуульд нэмэлт өөрчлөлт орсон.	1,2-р сард: Сүхбаатар, Төв аймгийн 40 сумын 2024 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнөөс эзэмшүүлэх, ашиглуулах жагсаалтыг гаргасан байна.	Сүхбаатар, Төв аймгийн 40 сумын 2024 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд эзэмшүүлж, ашиглуулахаар тусгасан нэгж талбаруудыг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, ашигт малтмалын лицензийн талбай, авто болон төмөр замын зурвастай	01-12	100

зохион батлуулах	байгуулж,	Улсын хэмжээнд эзэмшүүлж, ашиглуулах газрын жагсаалтыг нэгтгэн боловсруулж, ДДЗХ-р хэлэлцүүлсэн байна. 2024 онд шинээр эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтын Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалыг ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. 3-р сард: Улсын хэмжээнд 2024 онд шинээр эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг батлуулсан байна.	Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг нэгтгэн, 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр ДДЗХ-аар хэлэлцүүлсэн. ДДЗХ-аас гарсан саналын дагуу БОАЖЯ-наас ирүүлсэн саналыг тусган, улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга материалыг бэлтгэн 2024 оны 1/490 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын 2024 оны 04 сарын 03-ны өдрийн 136 дугаар тогтоолоор батлуулсан. Мөн газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөө баталсан, нэмэлт тодотгол хийсэн сумдын арга хэмжээнүүдийг нэгтгэж, эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг бэлтгэн Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг 2024 оны 05 дугаар сарын 17-ны 1/1282 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт гүн ухааны сургалттай цогцолбор хүрээ хийд байгуулах зориулалтаар эзэмшүүлэх газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулан 2024 оны 05 дугаар сарын 28-ны 1/1355 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлэн, Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 246 дугаар тогтоолоор батлуулсан. Мөн "2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг батлах тухай" Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 74, 2024	
---------------------	-----------	---	--	--

					оны 10 дугаар сарын 23-ний өдрийн 131 дүгээр тогтоолуудын төсөлд тусгагдсан Сүхбаатар, Төв аймгийн 40 сумын 2024 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд эзэмшүүлж, ашиглуулахаар тусгасан нэгж талбаруудыг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, ашигт малтмалын лицензийн талбай, авто болон төмөр замын зурвастай давхацсан, хууль тогтоомж зөрчиж төлөвлөсөн зэрэг хяналтыг гүйцэтгэж ажилласан.		
10	Арга хэмжээ 1.6.2. 2025 оны сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах	Хөвсгөл, Дорнод аймгийн 37 сум	2023 онд Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон.	9-12-р сард: Хөвсгөл, Дорнод аймгийн 37 сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дүгнэлт гаргаж, зөвлөмж чиглэлийг хүргүүлсэн байна.	Нэгжийн дотоод зохион байгуулалтаар Сүхбаатар, Төв аймгийн 40 сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон тодотголд дүгнэлт гаргадаг болсон. 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслөө боловсруулан ирүүлсэн Сүхбаатар аймгийн 10 сум, Төв аймгийн 4 сумын төлөвлөгөөнд дүгнэлт гарган аймгуудын ГХБХБГ-т дараах албан бичгүүдийг хүргүүлсэн.Үүнд: - Төв аймгийн Жаргалант, Бүрэн сумдын дүгнэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 2/3303 дугаар; - Төв аймгийн Сүмбэр, Баян-Өнжүүл сумдын дүгнэлтийг 2024 оны 12 дүгээр сарын 03-ны өдрийн 1/3348 дугаар; - Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Баяндэлгэр, Дарьганга, Мөнххаан, Онгон, Сүхбаатар, Түвшинширээ, Түмэнцогт, Халзан, Эрдэнэцагаан сумдын дүгнэлтийг 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 1/3349 дүгээр.	9-12	100
Зорилт 1.7.Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж							
11	Арга хэмжээ 1.7.1. Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг	Үүрэг даалгаврын тоо	-	Өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, тухай бүр тайлагнасан байна.	- Булган, Говь-Алтай аймгийн Монгол улсын иргэнд 2024 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг Газар зохион	01-12	100

	хэрэгжүүлэх, тайлагнах				байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүртгэгдсэн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, ашигт малтмал ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбай, авто зам, төмөр замын хамгаалалтын зурвас газрын мэдээлэлтэй давхцуулан шалгасан. - Нийслэл ГЗБА, 21 аймгийн ГХБХБГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан газар зохион байгуулалтын чиглэлээр гүйцэтгэсэн ажлуудыг дүгнэсэн. - Даргын дэргэдэх зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хурлаар Монгол Улсын иргэнд 2024 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын жагсаалтыг танилцуулсан. - Ерөнхийлөгчийн санаачилгаар 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулагдсан "Ой 9" ойн салбарын үндэсний 2 дугаар чуулганд оролцсон. - Тусгай хэрэгцээний газрын төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, Хот, тосгон, бусад суурин газрын төлөвлөлт, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж Газрын судалгаа шинжилгээ, бодлого төлөвлөлтийн газарт 2024 оны 03 дугаар сарын 11-нд хүргүүлж хянуулан, ТЗУГ-т 2024 оны 03 дугаар сарын 18-нд хүргүүлсэн. - ЗГХЭГ-ын дарга аймаг, нийслэл, сумын Засаг дарга нартай хийх цахим уулзалтын танилцуулга, өгөх үүрэг чиглэлийн төсөлд шаардлагатай мэдээлэл, танилцуулгыг бэлтгэн ГЗХХ-т 2024 оны 03 дугаар сарын 14-нд хүргүүлсэн. - Хэнтий аймгийн ГХБХБГ-ын албан хаагч, газрын даамлуудад 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр Газар зохион байгуулалтын төлөвлөгөө,
--	---------------------------	--	--	--	--

					тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудал, Газар зохион байгуулалт хийх шинэчилсэн журмын чиглэлээр чадавхжуулах сургалтыг хийсэн. - Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд "Бүсчилсэн хөгжил, орон зайн төлөвлөлтийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, тулгамдаж буй асуудлууд сэдэвт салбар дундын хурал"-ыг 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан. - Дорноговь аймагт 2024 оны 04 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд зохион байгуулагдсан бүсчилсэн сургалтад Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудал, Газар зохион байгуулалт хийх шинэчилсэн журмын чиглэлээр чадавхжуулах сургалтыг хийсэн. - Газар зохион байгуулалт болон хот төлөвлөлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагыг чадавхжуулах сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан. - 21 аймгийн ГХБХБГ-ын Газар зохион байгуулалтын төлөвлөлт хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 06-нд зохион байгуулсан. - Байгууллагын цахим хуудсанд оруулах мэдээллийг нэгтгэж Мэдээлэл, технологийн хэлтэст 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлсэн. - 2025 оны төсвийн төлөвлөгөөнд газар зохион байгуулалтын чиглэлээр хийгдэх ажлын саналыг боловсруулж Санхүү, эдийн засгийн хэлтэст 2024
--	--	--	--	--	--

12	Арга хэмжээ 1.7.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх	Тушаалд заасан хугацаа	-	Ажлын хэсэгт хэрэгжилтийг тухай тайлагнасан байна.	оны 08 дугаар сарын 16, 09 дүгээр сарын 20-ны өдөр хүргүүлсэн. - 70 жилийн ойн номонд оруулах Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй холбогдох мэдээллийг архивын хэлтсийн лавлагаа материалаас авч, нэгтгэсэн. - Засгийн газрын 2024 оны 136, 2024 оны 74 дүгээр тогтоолуудаар батлагдсан Сүхбаатар, Төв аймгуудын баталгаажуулалтын нэгж талбар төслийн судалгааг авч, бусад нэгж талбаруудыг цахим системд идэвхтэй төлөвт шилжүүлсэн. - Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудад томилолтоор ажиллахтай холбогдуулан Газар зохион байгуулалтын төлөвлөлт, кадастр, мониторингийн чиглэлээр мэдээлэл танилцуулга бэлтгэсэн. - Газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/199 дүгээр тушаалаар байгуулагдсан "Нийтийн сервитут тогтоосон газарт нөхөх олговрын хэмжээг тооцох, нөхөх олговрыг тогтоох, нөхөх олговрыг дүйцүүлэн тооцож олгох журам"-ын төсөлд газар зохион байгуулалтын чиглэлээр санал боловсруулан 2024 оны 01 дүгээр сарын 24-нд Газрын биржийн хэлтсийн мэргэжилтэнд хүргүүлсэн. - Газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны А/01 дүгээр тушаалаар батлагдсан ажлын хэсэгт ажиллаж, газар зохион байгуулалтын чиглэлээр тайланд тусгуулах ажлыг нэгтгэн 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Кадастрын хэлтэст хүргүүлж, ДДЗХ-аар хэлэлцүүлсэн. - Газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын А/194 дүгээр тушаалаар батлагдсан ажлын хэсэгт ажиллаж Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны журам"-ын төсөлд Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн	01-12	100
----	--	------------------------	---	--	--	-------	-----

					цахим системийн үйл ажиллагаатай холбоотой санал өгсөн. - Газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/48 дүгээр тушаалаар батлагдсан ажлын хэсэгт ажиллаж Дархан-Уул аймгийн Шарын гол сум, Сэлэнгэ аймгийн Сайхан сумдын 2003-2023 он хүртэлх иргэн хуулийн этгээдэд газар өмчлүүлсэн, ашиглуулсан, эзэмшүүлсэн асуудлыг шалгаж, хяналтын ажлын тайлан гаргасан. - Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын гол чиглэлийн авто зам дагуух үйлчилгээний цогцолбор барих ажлын хэсэгт орж ажиллан 58 байршлын давхцалыг шалгаж мэдээллээр хангаж 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 1/1437 дугаар албан бичгээр хүргүүлж, Засгийн газрын 2024 оны 189 дүгээр "Ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор барьж байгуулах тухай" тогтоолын дагуу эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг Засгийн газрын 2024 оны 74 дүгээр тогтоолоор батлуулсан. - Газрын даргын 2023 оны А/124 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсэг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу ажлуудыг гүйцэтгэн тайланг тус гэрээг хэрэгжүүлэгч Дорнод Монголын хуурай хээрийн ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал" төсөлд 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 1/2054 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. - Газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/98 дугаар тушаалаар байгуулсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт ажиллаж
--	--	--	--	--	--

				газар зохион байгуулалтын чиглэлээр санал өгч ажиллаа. - Газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/235 дугаар тушаалаар байгуулсан "Газрын харилцааны мэдээлэл" сэтгүүлийн 70 жилийн ойн баярын дугаар гаргах" ажлын хэсэгт орж ажиллан гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний дагуу Нийслэлийн ГЗБА, 21 аймгийн ГХБХБГ-т 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 3/2238 дугаар албан бичгийг хүргүүлэн газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар баталсан 70 бүтээлч ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг авч, нэгтгэсэн. - Газрын даргын 2024 оны А/87 дугаар "Евразийн орон зайн өгөгдлийн дэд бүтцийн 10 дугаар хурлыг зохион байгуулах" ажлын хэсэгт томилогдон ажиллаж хурлын бэлтгэл ажил, зохион байгуулалтад оролцсон. - УИХ-ын 2024 оны 42 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх дэд ажлын хэсэгт орж "Шинэ хоршоо хөдөлгөө"-ний хүрээнд газартай холбоотой хийгдсэн тайлан мэдээллийг цахимаар хүргүүлсэн.			
13	Арга хэмжээ 1.7.3. Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах	Тогтоол, шийдвэрийн тоо	-	Холбогдох тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд нь тайлагнасан байна.	Засгийн газрын 2024 оны 136 дугаар тогтоол болон тэмдэглэлийн биелэлтийг гаргасан.	01-12	100
14	Арга хэмжээ 1.7.4. Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах	Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл, гомдлын тоо	-	Нэгжид ирсэн хугацаатай албан бичиг, өргөдөл гомдлыг заасан хугацаанд нь шийдвэрлэсэн байна.	2024 оны жилийн эцсийн байдлаар 8 өргөдөл, 46 албан бичгийг судлан шийдвэрлэж хариуг заасан хугацаанд өгч ажилласан.	01-12	100
15	Арга хэмжээ 1.7.5. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх	Архивт хүлээлгэн өгсөн баримтын тоо	-	Нэгжийн урьд онд хийсэн ажлын баримт бичгийг тайлант оны эхний улиралд багтаан байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан байна.	Хэнтий аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулсан ажлын тайланг хүлээн авч, дүгнэлт гарган 2024/ГЗБ/03, Сэлэнгэ аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулсан ажлын тайланг хүлээн авч дүгнэлт гарган 2024/ГЗБ/07, Газар	01-12	100

						зохион байгуулалтын төлөвлөлт болон газрын мониторингийн арга аргачлалыг сайжруулах" ажлын эцсийн тайлан 2 зөвлөхөөс хүлээн авч дүгнэлт гарган 2024/ГЗБ/10, 2024/ГЗБ/11 дугаартай актаар тус тус Архивын хэлтэс хүлээн авсан.		
--	--	--	--	--	--	---	--	--

Нэмэлт үүрэг даалгаварын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дүгнэлт гаргах	Сүхбаатар, Төв аймгийн сумд	-	Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон нэмэлт тодотголын төсөлд дүгнэлт гаргасан байна.	Дүгнэлт гарах ажилтай холбогдуулан 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөндөө "Шинэ хоршоо хөдөлгөөн" болон Газар зохион байгуулалт хийх журмын дагуу тодотгол хийгдсэн Дархан-Уул аймгийн 3, Сүхбаатар аймгийн 7, Төв аймгийн 7 сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд дүгнэлт гарган аймгуудын ГХБХБГ-т дараах албан бичгээр хүргүүлсэн. - Дархан-Уул аймгийн Шарын гол, Орхон, Хонгор сумын дүгнэлтийг 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 1/1377 дугаар; - Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын дүгнэлтийг 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 2/1385 дугаар; - Сүхбаатар аймгийн Дарьганга сумын дүгнэлтийг 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 2/1390 дүгээр; - Сүхбаатар аймгийн Халзан, Сүхбаатар аймгийн дүгнэлтийг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 1/1489 дүгээр; - Сүхбаатар аймгийн Асгат сумын дүгнэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 1/2424 дүгээр; - Сүхбаатар аймгийн Онгон, Түвшинширээ сумын дүгнэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 1/2436 дугаар;	05-10	100

					- Төв аймгийн Борнуур, Лүн, Мөнгөнморьт, Сүмбэр сумдын дүгнэлтийг 2024 оны 06 дугаар сарын 18-ны 2/1578 дугаар; - Төв аймгийн Эрдэнэ сумын дүгнэлтийг 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 1/1425 дугаар; - Төв аймгийн Цээл сумын дүгнэлтийг 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 2/1543 дүгээр. - Төв аймгийн Эрдэнэсант сумын дүгнэлтийг 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 1/2699 дүгээр
--	--	--	--	--	---

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн (биелэлт)	түвшин		
	1	2	3	4	5	6	7	
1.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 18-ны 96 дугаар тогтоолоор баталсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III", Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эх хэл, бичиг үсэг, түүх, соёлын дурсгалаа судалж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.	Дунд шатны гэрчилгээ	2023 онд анхан шатны хичээлийг судалж анхан шатны гэрчилгээтэй болсон.	Үндэсний монгол бичгээ судалж, дунд шатны цахим сургалтад хамрагдсан байна.	Үндэсний монгол бичгээ цахимаар судалж дунд шатны цахим сургалтад хамрагдаж гэрчилгээтэй болсон.	01-12	100	
2.	Газар зохион байгуулалтын мэргэшсэн инженерийн сургалтад хамрагдсан байна.	Гэрчилгээ	-	Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн мэргэшсэн инженерийн сургалтыг судалж, шалгалт өгсөн байна.	Мэргэшүүлэх сургалтын зохион байгуулалтад өөрчлөлт гарсан тул хүлээгдэж байна.	01-12	-	

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

L. Montagne

Г.ГЭРЭЛТУЯА

2024.12.04